

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сүнрэвийн Батбаяр	Дугаар	L123
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Эрдэнэцагаан
Төрсөн газар	Эрдэнэцагаан	Төрсөн он	1948
Ажил мэргэжил	Эрдэнэцагаан сумын дунд сургуулийн багш		
Лам байсан эсэх, Шавилан сүүж байсан сүм хийд	Егүзэрийн хийд	Сүм хийдийн дугаар	СБЭЦ 002
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Егүзэрийн хийд

Егүзэр хутагтын тухай-Егүзэр хутагт нэг намар Хөндлөн хайлс гэдэг газарт байсан Эрээт /туслах аж ахуй/ дээрээ очоод байжээ. Энэ нь Хятадын хар цэрэг цөмрөн орж ирэхийн өмнөхөн 1915 оны намар цаг бололтой. Өндөр яамнаас ирсэн бичгийг Дашзэвэг захирагч Ламхайд танилцуулахаар очиход тэр их хөлчүүрхсэн янзтай байснаа мориндоо мордон миний хойноос хүн битгий очоорой гээд давхиад явчихжээ. Гэтэл хамт байсан сойвон сэтгэл нь зовж хойноос нь яваад уулын ганга руу өнгийтөл Егүзэр ганганд морио түшиж орхиод цаахна нь чонотой ноцолдож байхыг хараад тэр тэвдсэндээ тэссэнгүй хашгирчихсан чинь чоноо тавьж явуулчихаад сойвонгоо нэлээд бэрээдэж “болох л байсан юм, чи л болохгүй болгочихлоо. Богдын ордонд сэв оржээ. Тэр чоныг цааш харуулж чадаагүйгээс болов” гэж байсан гэнэ. Нутгийнхан энэ чоныг алаагүйгээс болж Хятад хар цэрэг ирж Ламхайг барьж явах ёр удсан шалтгаан болсон байх гэгцгээдэг байжээ.

Егүзэр намар буу үүрч хааяа зээр агнахаар дагалдах анчидтайгаа явдаг байж. Анчид Егүзэрт агнуулах гэж том тарган оонотой хэсгийг эргүүлж тойруулаад буудах боломж олгосон байхад тэр буудахгүй босоод зээрээ үргэчихээд байхад нь нөгөөдүүл нь залхаж “ Гөрөөс өөрийг чинь дайрчих шахав. Та яагаа вэ?” гэхэд миний алах гэсэн зээр алга байна шүү дээ гэхэд анчид нь Ламхай та ямар зээр болгоох гэсэн юм бэ? гэхэд тэр Та нар залхуураагүй бол дахиад... гээд хуруугаараа нэг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бор толгойн энгэрт яваа зээрийг заан ойртуулаач гэжээ. Дагалдах анчид дотроо үл таашаавч: Бид яалаа гэж залхуурах вэ?тэгье гэлцэн тэр зээрийг морины хүч, эвээр эргүүлэхэд тэдний дотор нэг сувай шаргачин солбин гүйж тогтвор алдуулаад байсан ч Ламхайн зарлиг болсон хойно туршлагатай анчид хөөн шахсаар ойртуулангуут буу дуугарч нөгөө шаргачин дээш ойн үсэрч унах харагджээ. Дагалдагчид давхин очоод агнасан шаргачинг авах гэхэд, түүнийг авах хэрэггүй, гар хүрэлгүй орхиорой. За боллоо! Буцацгаая гээд сүм рүүгээ явцгааж , тэгэхдээ зээр эргүүлсэн анчиддаа, Хүүхэд багачууд чинь горьдох байлгүй. Манайхан тэнгэрээс гуйгаад нэг ооно агнаж аваач л даа гэжээ. Цуг явсан хүнээс нь нэг нь гэртээ ирээд морин тэрэгтэй хүүгийн хамт яваа уг шаргачинг авахаар явжээ. Орой болж сар гарсны дараа энэ л хавьд байсан болов уу гээд очсон чинь сарны гэрэлд тал алаг амьтан харагдсанд айгаад хүүгээрээ тэргээ хөтлүүлэн буцаж харих замдаа солиорчээ. Энэ үед гэрийнхэн нь Ламхайд айлтгасанд бүү ав гэж байхад буцаж очоо биз. Үүнийг уулга гээд тан өгсөн гэж зарим хүмүүс ярилцдаг. Харин бусад ангийн хорхойтон нь сэтгэл дундуур буцсан боловч “Цаанаа л нэг учир начиртай байснаас зэтгэр болсон шаргачинг далд оруулав бололтой. Бурхан минь, бидний зээр гөрөөлөх нэг хэрэг, Ламхайн зорьсон нь бүтсэн нь яамай” хэмээн залбиран өнгөрсөн ажээ.

Егүээр ламхай нэг өдөр хоёр хар хүнийг хөтөлгөө морьтой Хуучид хамбад очоод над нэг хайрцаг тугалга хэрэгтэй байна гэж хэлээд, өгвөл аваад ир гэж явуулж гэнэ. Тэр хоёр Хуучид хамбад очоод хэлсэн чинь за оройхон очиж Хайрханд гаръя тэгээд авч өгье гэжээ. Очсон хүн гайхаж оройхон Сайн -Ерөөлт хэмээх гөрөөчин хүнийг дагуулаад явж Өгий хайрханы өвөрт их хадан хясаанд гарчээ. Тэндээс эрж байж нэг хавтгай чулуу олоод хүнээр нэг буланг нь өргүүлж сөхөхөд олон төмөр хайрцагтай тугалга байжээ. Тэгээд нэг хайрцагийг аваад өгсөн гэнэ. Түүнийг үзсэн Сайн-Ерөөлт маргааш нь очоод авах гээд эрээд эрээд олоогүй гэдэг.

Нэгэн өдөр Ламхай юмнаас айдаггүй шавиа дагуулан Өвөр монгол руу шөнө гараад нэгэн баяны тэмээнээс нэг ингэ хөтлөөд өглөө нь хүрээд иржээ. Тэр баяны эхнэр хойноос нь нэхэн ирж “ Хулгайч лам ингийг минь дээрэмдлээ” гэж гэнэ. Эзэн нь юмаа мэддэг юм гээд тэмээн дээрээ очтол дэргэр үстэй эхнэр болчихсон уяатай байхыг үзээд, ээ лам минь гээд ухаан алдаад уначихжээ. Сэргэхлээр нь за та тэмээгээ авах уу гэхэд Ламхай минь! Манайх гэдэг айл энэ жил их зовлон амсаж нөхөр маань нас бараад би бие их өвдөөд байгаа юм гэжээ. Тэгвэл танай муу ёр /амилсан чөтгөрийг/-ыг чинь дарж өглөө гэжээ. Тэр баяных Ламхайд нэг лавиранг хөрөнгөөрөө бариулж өгсөн гэдэг.

Ононгийн рашаанд залраад байхад нь буриадууд ламд мөргөж, буриад нутагт залж олон ном тавиулан Онон голын хойт дээр Хирийн дуган барьж өгч гэнэ. Үүнээс хойш жил бүр тэнд заларч буриадуудад авшиг хүртээдэг болсон гэдэг. Нэг жил Дамдинбишрэлтийг дагуулан очоод нэгэн их айхтар догшин бөөг номхотгож байсныг нүдээр үзсэн буриадын хамба байсан Эрдээл /Жамба/ гэдэг хүн ярьж байсныг гавж Г.Даваасамбуу гуай тэмдэглэжээ.

Егүээр ламхайн Цогчэн /их жас/ ядуу байсанд ламхай нэг өдөр дооромбо лам Авгаанлуvsанбалдан-Ишийг дуудан олон төрлийн Намсрай бурхныг нэгэн бөөн ном болгон том тахилгын ном / ганшил/ зохио гэжээ. “ Хүсэл бүхний цог баялаг,чандмана эрдэнийн хайрцаг /хуурцаг/ “ хэмээх номыг бичээд Ланхайд барьсанд маш ихээр баясаж “ За одоо энэ номоо долоо хоног их жасад тахин, мөргөн уншуул” гэсэнд олон лам нар уншсаны дараахан жас их баян болсон юм гэнэ билээ гэж тус хийдийн шавь гэвш Х.Дүгэр ярьсныг мөнхүү Г.Даваасамбуу гуай тэмдэглэжээ.

Егүээр ламхай Ононгийн рашаанд орж биеэ сувилуулахаар хэд хэдэн удаа явсан ба нэг удаа шумуул ихтэй зун таарч тавгүй байсанд гөвүүрээрээ гөвж, савж ядраад ууж суусан аягатай цайгаа нэг ламд өгч Должин соргог дог / Жамсран бурхны нэр/-ийг шумуул хорьж бай гэж хэлээд майхан тойруулаад цац гээд цацуулжээ. /Зарим тохиолдолд хөвчөөс буцаж явахдаа говийн Баяндулаанд гэдэг яриа бий/ Гэтэл Ламхайн майхан дорхноо шумуулгүй болж гэнэ. Егүээр хутагт удалгүй хөдөлж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нэлээд явснаа –Ээ би нэг юм мартаж гээд хоёр хүнд чимх шороо, атга арвайн хамт өгч та хоёр миний майхан байсан газарт “Должин сорог догийг одоо боль” гээд үүнийг цацаад ир гэж буцаж явуулжээ. / Зарим тохиолдолд Өргөний даваан дээрээс/. Тэр хоёр хүнийг очиход Егүзэр ламын майхны ор шумуулгүй харлан бөмбийж харагдсан тул нөгөө шороо, арвайг нь цацуут майхны буурин дээр шумуул пүп гээд бүчээд авахыг үзсэн тэр хоёр хүн тун ихээр гайхсан гэнэ билээ.

Нутгийн Лэг гэдэг эр Егүзэр ламтай ойролцоо насных байжээ. Энэ хүн бага сага хулгай хийгээд байж. Үүнийг Егүзэр сонсоод Лэгийг дуудан уулзаж “ Чи ногт жаахан гүйлгээд байгаа сурагтай. Сайн л хулгайч юм бол надад зөв талын өсгий цагаан хөө хар морь нэгийг олж аль” гээд гурван жилийн хугацаа өгчээ. Лэг халх болон өвөр 49 хошуу, богдын шавиар яваад тиймийг олж чадаагүй залхсан учир Егүзэр хутагтад үүнийгээ айлтгасанд “ За чи үүнээс хойш хулгай хийж болохгүй шүү “ гэснээс хойш нэг ч хулгай хийгээгүй гэдэг.

Нутагт нь Өлзийхүүгийн Өлзиймэнд гэдэг нилээд бяртай ядуу хүн байж. Тэр Егүзэр ламд бараалхаж жасынхаа адуунаас эмнэг сүргүүлж үнүүлаач гэж гүйжээ. Тэгээд өдөр болзон адуун дээрээ очих болж, тэр өдрөө Егүзэр ч хөдөө Эрээтийн адуун дээрээ очиж Өлзиймэндийг байхыг хараад адуун сүргийн даамалдаа энэ хүнд сургах сайхан эмнэг зааж өг гэснээр олон жил барьж сургаж чадаагүй нэг эмнэгийг зааж харуулжээ. Бүсэндээ хазаар хавчуулсан хүү адууг нь хураалган дунд нь гүйж ороод эмнэг хангалын дээр нь морьдчихсон булгиулж, булгиулж цуцаан хазаарлаж байхыг хараад Егүзэр бахархан харж “Үнэхээр адуунд сайн золбоотой хүү юм. Энэ морио түүнд өгөөрэй. Тэр хүү дуртай эмнэгээ сургаж байг” гэжээ.

Хийдийн дэргэдэх шашин номын болон үзвэр үйлчилгээнээс

Манай сумын өндөр настан С.Хоролсүрэн /1915-1999/ гуай “ Хууч яриа” дурсамжийн номондоо Егүзэрийн хийдэд болж байсан шашны зарим зан үйлийн талаар: Барс сар буюу цагаан сарын 15-ны шөнө Цогчэн дуганы хойд талд хиймэл дөрвөн уул босгож, түүндээ элдэв хүн амьтны дүрс зэргийг хийж үзүүлэх бөгөөд үүнд хошууныхан цуглардаг байлаа. Зуны эхэн сард “Маани үрэл хурах” гэж нэг хурал болдог. Энэ үеэр настан хөгшдийн уншсан маанийн тоог цуглуулдаг учиртай.

Зуны адаг сар буюу бичин сарын 9-10-ны өдрүүдэд хурал хурж, цам гарч, сор залдаг, майдар эргэдэг байв. Човдон ба цам майдарт ойр хавийн хошууны мөргөлчид, сонирхогчид их ирдэгсэн. Дарьганга дахь цэргийн ангийн дарга нар өртөөгөөр ирж үзэх жишээтэй.

Тусгай бэлтгэсэн гоё хувцастай янз бүрийн багтай хүмүүс оролцдог цамын бүрэлдэхүүн гэвэл

1.Чойжоо бол том биетэй үхэр тэргүүтэй

2.Цагаан өвгөн хоёр хүүхдийн хамт

3.Хохимой

4.Хашин хаан хүүхдийн хамт

5.Шаваамаахай хэмээх буга, бухын толгойтой хурдан хөдөлгөөнтэй

6.Азар

7.Бэгз Намсрай гэх зэргийн тусгай дэг бүхий дэвсгэр дээр хэнгэрэг цан, бүрээ бишгүүрийн аяар бүжиглэнэ.

Намар цагт хошуу сүмд харъяат лам нар цугларч хурдаг хурал байв. Үүнийг хошуу хурал гэнэ. Мөн таван аймгийн лам нар тус бүртээ цугларч 2-3 хоног хурахыг “ Хамцан хурал” гэдэг. Өвлийн адаг сар буюу үхэр сард “Дацан няллага” хэмээх хурал хурна. Энэ үеэр Санжид Моломыг өдөр шөнөгүй дуу тасрахгүй уншиж, битүүний урд өдөр сор залж, зүүн хойно бунхны хөтлөөр гарган шатаадаг байв гэж ярьсан байдаг.

Човдон буюу жун-аан Чодба гэдэг нь янз бүрийн хүүхэлдэй хийж жил бүр хаврын тэргүүн сарын 15-ны үдэш тоглуулдаг.

Одоогийнхоор бол таяган хүүхэлдэй шиг зүйл. Үүнд: модтой ууланд бар, чоно, буга зэрэг араатан амьтад гүйдэх, анчин

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

буу буудах, хуц мөргөлдөх, бороо орж солонго татах, хоёр өвгөн ноцолдож алиалах, сүмд лам нар хурал хурах, хүрэн жанчтай гэсгүй жаяг зөрчсөн лам нарыг бэрээдэх, бишгүүр үлээж хэнгэрэг, цан зэрэг үйл хөдлөлийг сонирхолтой тоглон үзүүлдэг аж. Тэдгээрийг өнгө будаг зохицсон, лаа дэн, хүжийн галаар гэрэл сүүдрийг тохируулдаг байв. Үүл нүүлгэж байгааг будагтай олгой, гүзээ зэргээр хийнэ. Бороо орохыг ус шүрших, аянга цахилгааныг хүжийн галаар үзүүлэх ба эдгээрийг утас юмуу нугасаар хөдөлгөдөг байжээ. Энэхүү үзвэрүүдийг бүтээхэд дээр дурьдсан Дархан Гэндэн ламаар удирдуулан гарын дүйтэй залуу лам нарыг бүлгэм болгож хийлгэдэг ба уран Чойгоо, янзага Жамба нар гол үүрэгтэй байсныг нутгийн буурлууд хуучилдаг.

Егүзэр хутагт нь бэлчээр болон гар тэжээлээр тэжээдэг бардаагаар 21 зүйл амьтантай амьтны хүрээлэнтэй байсан тухай нэрт газар зүйч асан О.Намнандорж гуай бичиж үлдээжээ. Хийд дээрээ ёл, тас, бүргэд, хун, хонгор, галуу, тогос, тоть, улаан хошуут /жунгаа/, тагтаа зэрэг арваад шувуу мүүр, хар үнэг, хярс, мануул, илбэнх зэрэг амьтдыг журамтай тэжээж зон олонд үзмэр болгон үзүүлдэг байжээ.